

## **АКТУАРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ, АКТУАРЫН СТАНДАРТ, ҮНЭЛГЭЭ БОЛОН АКТУАРЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, ТАЙЛАН ГАРГАХ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх (цаашид “актуарчийн эрх” гэх) олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан даатгалын багц дүрмийг мөрдлөг болгоно.

### **ХОЁР. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох**

2.1. Даатгалын тухай хуулийн 39.1 дэх заалтын дагуу дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “этгээд” гэх)-ийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг Даатгалын асуудал эрхэлсэн газрын саналыг үндэслэн Хорооны даргын тушаалаар олгоно:

2.1.1. Эдийн засагч, статистикч, санхүүч, математикч, эдийн засгийн математик загварчлал зэрэг мэргэжлээр их дээд сургуулийн хөтөлбөрийг хангасан;

2.1.2. Олон улсын актуарчдын холбоо, түүний жинхэнэ гишүүн байгууллагаас гадаад болон Монгол Улсад зохион байгуулсан актуарчийн мэргэжлийн дараахь шалгалттай дүйцэхүйц шалгалтыг өгч тэнцсэн; Үүнд:

2.1.2.1 Урт хугацааны даатгалын актуарч; (CT1-Financial mathematics, CT3-Probability and mathematical statistics, CT5-Contingencies)

2.1.2.2 Ердийн даатгалын актуарч; (CT1-Financial mathematics, CT3-Probability and mathematical statistics, CT6-Statistical models)

2.2. Монгол Улсын даатгалын тухай хууль тогтоомжийн талаар Хорооноос зохион байгуулсан шалгалтанд тэнцсэн олон улсын актуарчийн эрхтэй этгээдэд актуарчийн эрхийг шууд олгоно.

2.3. Актуарчийн эрхийг нь энэхүү журмын 5.3.4-т заасан үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 6 сар, бусад үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 1 жилийн хугацаа өнгөрсний дараагаар актуарчийн эрх шинээр авахыг хүсч өргөдлөө ирүүлсэн этгээдэд Хороо актуарчийн эрхийг дахин олгож болно.

2.4. Хороо актуарчийн эрхийг Даатгалын тухай хуулийн 6.1-д заасан даатгалын ангиллын дагуу олгоно:

2.4.1. Урт хугацааны даатгалын;

2.4.2. Ердийн даатгалын;

2.5. Актуарчийн эрх авахыг хүссэн этгээд өргөдлөө Хороонд энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн нотариатаар баталгаажсан хуулбарын хамт ирүүлнэ.

2.6. Хороо актуарчийн эрх авахыг хүссэн этгээдийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тодруулж, лавлагаа авч болно.

2.7. Актуарчийн эрх авсан этгээд тухайн компанид тасралтгүй 9 сар актуарчаар ажиллаагүй тохиолдолд санхүүгийн жилийн эцэст даатгалын нөөц санг тооцоолох, хяналт шалгалт хийх, актуарын хяналт шалгалтын тайлан (цаашид “актуарын тайлан” гэх)-г боловсруулах бол энэ тухай Хороонд бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авна.

2.8. Актуарчийн эрх авах этгээд энэхүү журмын 2.1.2-т заасан актуарчийн мэргэжлийн эхний шалгалтанд тэнцсэнээс хойш дараагийн шатны шалгалтыг 1 жилийн хугацааны дотор өгөх үүрэгтэй.

2.9. Актуарчийн эрх авсан этгээд 2 жилд нэгээс доошгүй удаа актуарчийн мэргэжлийн давтан сургалтанд хамрагдах үүрэгтэй.

### **ГУРАВ. Актуарын үйл ажиллагааны стандарт, үнэлгээ**

3.1. Актуарчийн эрх авсан этгээд нь актуарын дараахь стандарт, үнэлгээг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж гүйцэтгэнэ:

3.1.1. Хороонд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүн бүрээр зах зээлийн үнэлгээний өөрчлөлт, эрсдэлийн тооцоололд үндэслэн даатгалын хураамжийн хувь хэмжээг шинэчлэн тооцоолох;

3.1.2. Зах зээлд нийлүүлэх даатгалын шинэ бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг тооцоолох;

3.1.3. Даатгагчийн даатгалын нөөц сан, төлбөрийн чадварын үзүүлэлтийг улирал бүрээр тооцож, үр дүнг зохих хугацаанд нь Хороонд ирүүлж хянуулах;

3.1.4. Санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үүссэн даатгагчийн хариуцлага, нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолох;

3.1.5. Даатгалын нөөц сан байгуулахтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт тухайн оны явцад гарсан өөрчлөлт болон холбогдох санхүүгийн үзүүлэлтийг тооцоолж үнэлэлт дүгнэлт өгөх;

3.1.6. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд үндэслэн даатгагчийн санхүүгийн тогтвортой байдалд дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлийг

үнэлэх, эдийн засаг, математикийн тооцоо, судалгаанд суурилсан дүн шинжилгээ хийх;

- 3.1.7. Даатгалын эрсдэлийг үнэлж, даатгагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолсны үндсэн дээр давхар даатгагчид даатгуулах шаардлагатай эрсдэлийн хэмжээг тооцох;
- 3.1.8. Даатгагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлоход шаардлагатай актуарчийн үнэлгээ, зөвлөмж боловсруулах; (урт хугацаат даатгалын компаний актуарчид хамаарна)
- 3.1.9. Даатгалын хураамж, нөөц сангийн тооцоололтой холбоотой статистик мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн бааз байгуулж, баяжуулах;

#### **ДӨРӨВ. Актуарын хяналт шалгалт хийх, тайлан гаргах**

4.1. Даатгагч нь энэхүү журмын 3.1.4-3.1.9-д заасан актуарын стандарт, үнэлгээ болон хяналт шалгалтыг Даатгалын тухай хуулийн 42.4 дэх заалтын дагуу томилсон актуарчаар гүйцэтгүүлнэ.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан актуарч нь актуарын хяналт шалгалтын тайланг тус журмын хавсралтаар батлагдсан “Актуарын тайлангийн стандарт загвар”-ын дагуу боловсруулна.

4.3. Даатгалын хуулийн дагуу томилогдсон актуарч нь энэхүү журмын 4.1-д заасан актуарын хяналт шалгалтыг даатгагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор гүйцэтгэж, үр дүнг компанийн удирдлагад танилцуулах бөгөөд актуарын хяналт шалгалтын тайланг 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

4.4. Хороо нь актуарчаас ирүүлсэн даатгагчийн актуарын хяналт шалгалтын тайлантай танилцаж, хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд актуарчийн дүгнэлт, тооцооллын талаар тайлбар, тодруулга авна.

#### **ТАВ. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх**

5.1. Хороо актуарчийн эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

- 5.1.1. Актуарчийн эрх авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;
- 5.1.2. Актуарч нь актуарын хяналт шалгалтын тайлан, дүгнэлт боловсруулахдаа зах зээлийн болон даатгагчийн үнэн зөв мэдээлэл, тоо баримтад тулгуурлаагүй, тоон мэдээллийн өгөгдөхүүнийг өөрчилж мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасан болох нь тогтоогдсон;
- 5.1.3. Актуарын тайлан нь хангалттай мэдээлэл, дүгнэлт агуулаагүй, актуарын хяналт шалгалтын тайлангийн стандарт загварт нийцээгүй, ашигласан мэдээллийн эх үүсвэрийг үнэн зөв заагаагүй, актуарын стандарт, үнэлгээг

бүрэн хэрэгжүүлээгүй, актуарчийн үүргээ хангалтгүй биелүүлж гаргасан алдаа, зөрчлийг арилгах талаар Хорооны улсын байцаагчаас тухайн актуарчид өгсөн үүрэг, албан даалгавар, шаардлагыг 3 удаа биелүүлээгүй;

5.1.4. Актуарчийн эрх авснаас хойш мэргэжлээрээ даатгалын компанид тасралтгүй 9 сарын хугацаанд ажиллаагүй;

5.2. Актуарчийн эрхийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

5.2.1. Хорооноос тогтоосон 6 сар хүртэл хугацаагаар;

5.2.2. Хорооноос өгсөн хугацаатай үүрэг, албан даалгавар, шаардлагыг биелүүлэх хүртэл;

5.3. Хороо актуарчийн эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

5.3.1. Актуарчийн эрх авсан этгээд өөрөө хүсэлтээ гаргасан;

5.3.2. Актуарчийн үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлж, Даатгалын тухай хууль, даатгалын багц дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн;

5.3.3. Актуарчийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд алдаа, зөрчлийг арилгах талаар Хорооноос өгсөн үүрэг, албан даалгавар, шаардлагыг биелүүлээгүй;

5.3.4. Энэхүү журмын 5.1.4-т заасан үндэслэлээр актуарчийн эрхийг нь түдгэлзүүлснээс хойш 6 сарын хугацаанд уг этгээд дотоодын аль нэг даатгалын компани эсхүл төрийн байгууллагад актуарчийн албан тушаалд томилогдоогүй;

5.4. Актуарчийн эрхийг нь түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг, албан даалгавар, шаардлагыг бүрэн биелүүлж, гаргасан алдаа, зөрчлийг арилгасан талаар бичгээр тайлагнаж, актуарчийн эрхээ сэргээлгэх хүсэлтээ ирүүлсэн этгээдийн актуарчийн эрхийг Хороо сэргээж болно.

## **ЗУРГАА. Бусад**

6.1. Актуарчийн эрх авсан этгээд актуарчаар томилогдох, чөлөөлөгдөх, шилжин ажиллах болсон тохиолдол бүрт энэ тухай холбогдох эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр болон нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж баталгаажуулсан хуулбарыг ажлын 5 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

6.2. Актуарч нь ажлаасаа чөлөөлөгдөж гадаад болон Монгол Улсад 1 сараас дээш хугацаагаар мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх сургалтанд хамрагдах болсон тохиолдолд энэ тухай Хороонд бичгээр мэдэгдэнэ. Хороо актуарчийн эрхийг сургалтын хугацаанд хүчинтэйд тооцно.

6.3 Актуарчийн эрх авсан этгээд нь актуарын стандарт, үнэлгээ болон хяналт шалгалтыг гүйцэтгэх явцад ашиг сонирхолын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл бий болсон тохиолдолд энэ тухай Хороонд даруй мэдэгдэх үүрэгтэй. Энэ тохиолдолд Хороо тухайн актуарчийн оронд актуарын хяналт шалгалтыг өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлнэ.

## **ДОЛОО. Хүлээлгэх хариуцлага**

7.1. Актуарч нь өөрийн боловсруулсан актуарын хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийн үнэн зөв байдалд даатгалын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.2. Хорооны Ажлын алба нь энэ журмын хэрэгжилтэнд хяналт тавих бөгөөд зөрчил гаргасан этгээдэд Даатгалын тухай хуулийн 83.1.16-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Актуарч нь тухайн даатгалын компанид актуарчаар ажиллахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа ажлын 5 хоногийн дотор Хороонд мэгдэгдэж байх.

----- оОо -----

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын хавсралт

## АКТУАРЫН ТАЙЛАНГИЙН СТАНДАРТ ЗАГВАР

1. Актуарч нь даатгагчийн актуарын хяналт шалгалтын тайланг энэхүү стандарт загварын дагуу боловсруулж, үр дүнг даатгалын компанийн удирдлагад танилцуулах бөгөөд актуарын тайланг Хороонд ирүүлнэ.

2. Актуарын тайлан нь дараахь агуулгатай байна.

Дугаар	Сэдвийн нэр
1	Тайлангийн зорилго, хамрах хүрээ
2	Тайлангийн агуулга
2.1	<ul style="list-style-type: none"> <li>• Хамралтын хугацаа</li> </ul>
2.2	<ul style="list-style-type: none"> <li>• Актуарын тооцоололд нөлөөлсөн хууль эрх зүйн шаардлага</li> </ul>
2.3	<ul style="list-style-type: none"> <li>• Актуарын тооцоололд нөлөөлсөн компанийн дотоод хүчин зүйл</li> </ul>
3	Таамаглалууд
3.1	<ul style="list-style-type: none"> <li>• Актуарын таамаглал</li> </ul>
3.2	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн таамаглал <ul style="list-style-type: none"> <li>○ Инфляци</li> <li>○ Хүүгийн өөрчлөлт</li> <li>○ Хөрөнгийн өөрчлөлт</li> <li>○ Хүн ам, тээврийн хэрэгслийн болон нөлөө үзүүлэх бусад хүчин зүйлийн тоон үзүүлэлтийн таамаглал</li> </ul> </li> </ul>
4	Аргачлал болон үр дүн
4.1	<ul style="list-style-type: none"> <li>• Тооцооллын зорилго</li> </ul>
4.2	<ul style="list-style-type: none"> <li>• Тооцоололд ашигласан аргачлал</li> </ul>
4.3	<ul style="list-style-type: none"> <li>• Өмнөх тайлангаар өгсөн актуарчийн зөвлөмжийн биелэлт</li> </ul>
4.4	<ul style="list-style-type: none"> <li>• Нөөц сангийн тооцооллын үр дүн</li> </ul>
4.5	<ul style="list-style-type: none"> <li>• Үр дүн болон тооцооллын загварын баталгаажуулалт, тест</li> </ul>
5	Эрсдэлийн үнэлгээ
5.1	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөөллийн мэдрэмтгий байдлын тест (Sensitivity test to assumptions)</li> </ul>
5.2	<ul style="list-style-type: none"> <li>• Зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмтгий байдлын тест (Sensitivity test to market changes)</li> </ul>
5.3	<ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох бусад эрсдэлүүд</li> </ul>
5.4	<ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн удирдлага</li> </ul>
6	Холбогдох зүйлс
6.1	<ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөмж</li> </ul>
6.2	<ul style="list-style-type: none"> <li>• Дүгнэлт</li> </ul>
7	Тайлангийн найдвартай болон хязгаарлагдмал байдал
7.1	<ul style="list-style-type: none"> <li>• Найдвартай байдал</li> </ul>
7.2	<ul style="list-style-type: none"> <li>• Хязгаарлагдмал байдал</li> </ul>
8	Хавсралтууд

(Урт хугацааны даатгагчийн хувьд компанийн өөрийн үйл ажиллагаа болон даатгалын бүтээгдэхүүний онцлогт тохирсон холбогдох мэдээллийг тайлагнана.)

3. Актуарын тайлангийн загварт орсон нэр томъёог дараахь утгаар ойлгоно. Үүнд:
  - 3.1. Зорилго гэдэгт тухайн актуарын тайлангийн зорилгыг тодорхойлж, тайлангийн захиалагч, хяналт шалгалтыг гүйцэтгэж тайланг боловсруулсан актуарчдын нэр, туршлага зэрэг мэдээллийг оруулна;
  - 3.2. Хамрах хүрээ гэдэгт актуарын тайланг хэрэглээх хүрээг дурьдана;
  - 3.3. Актуарын тооцоололд нөлөөлсөн хууль эрх зүйн шаардлага гэдэгт актуарын тайлангийн стандарт загвар болон даатгалын багц дүрэмд харшлаагүй заавар, зөвлөмжийг дагаж мөрдсөн тухай бичнэ;
  - 3.4 Тооцоололд ашигласан тоон мэдээлэл гэдэгт актуарчийн авч ашигласан өгөгдөхүүнд итгэж болох байдал, хамрах хугацаа, мэдээллийн бодит эх сурвалж, мэдээллийн харьцуулалтын тухай бичнэ;
  - 3.5 Таамаглал гэдэгт актуарын тооцооллын таамаглал болон тооцооллын үр дүнд нөлөөлөх, загварчлалд ашигласан хүчин зүйлсийн үнэлгээ, өөрчлөлтийн талаарх таамаглалыг ойлгоно;
  - 3.6 Тооцоололд ашигласан аргачлал гэдэгт гинжин шатны арга (Chain ladder method), Борнхуеттер-Фергюсоны арга (Bornhuetter-Ferguson method), шугаман регресс (Linear regression) болон актуар тооцооллын бусад аддитив аргаас тодорхой 2-3 аргыг сонгож тооцоолол хийхийн хамт өмнөх онуудын өгөгдлөөр нөхөн төлбөрийн хөгжлийн гурвалжинг байгуулж дүн шинжилгээ хийхийг ойлгоно;
  - 3.7 Нөөц сангийн тооцооллын үр дүн гэдэгт даатгалын нөөц сангийн улирлын тооцоолол болон актуарын хяналт шалгалтаар даатгагчийн даатгалын нөөц сангийн тооцоололд өгөх үнэлэлт бие даасан хараат бус шинжтэй байхыг ойлгоно;
  - 3.8 Үр дүн болон тооцооллын загварын баталгаажуулалт, тест гэдэгт өмнө нь ашигласан тооцооллын загварын болон бодит нөхцөл байдлын тоон үзүүлэлтийг харьцуулсан шинжилгээ хийх, шаардалагатай тохиолдолд загвар болон аргачлал дээр тохируулга оруулахыг ойлгоно;
  - 3.9 Эрсдэлийн үнэлгээ гэдэгт тухайн тооцооллын загвар, актуарын төсөөлөл нь зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмтгий байгаа байдал, холбогдох бусад эрсдэл, тэдгээрийг удирдах арга замын талаарх зөвлөмжийг ойлгоно;
  - 3.10 Зөвлөмж гэдэгт хяналт шалгалтаар цаашид анхаарах, авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийн талаар актуарчаас өгсөн зөвлөмжийг ойлгоно;
  - 3.11 Тайлангийн найдвартай болон хязгаарлалтын байдал гэдэгт актуарчийн хийсэн дүгнэлт, тооцооллын үр дүнд итгэж болох найдвартай байдлыг баталгаажуулах бөгөөд тухайн үр дүнгүүдийг гаргахад дутагдалтай, хязгаарлагдмал мэдээлэл, нөхцөлүүд болон бусад зүйлсийг тусгахыг ойлгоно;
  - 3.12 Хавсралтууд гэдэгт санхүүгийн тайланд тусгагдаагүй үр дүн, актуарын тооцоололд ашигласан түүхчилсэн мэдээлэл, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийн эх сурвалж, холбогдох бусад мэдээ, мэдээллийг тайлбар, дугаарлалт бүхий цахим файлаар Хороонд ирүүлэхийг ойлгоно;